

"Ариг гал" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
дэг

Хурлыг 2015 оны 04 сарын 29-ны өдрийн 17 цагт компанийн хурлын танхимд хуралдуулна.

Хурлаар хэлэлцэх асуудал:

7. Хувьцаа эзэмшигчдийн ирц бүртгэх
(хурлын нарийн бичгийн дарга) цаг тогтоохгүй
8. Хувь эзэмшигчдийн хуралд Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны талаар гүйцэтгэх захирлаас тавих тайлан илтгэл
(Гүйцэтгэх захирал Х.Хания) 15 мин
9. Төлөөлөн Удирдлэх Зөвлөлөөс компанийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлт, аудитын байгууллагын дүгнэлт
(Аудитын хорооны гишүүн Д.Гиваапил) 10 мин
10. Зохион байгуулалтын асуудал
 - a. ТУЗ-ийн энгийн гишүүдийг сонгох
 - b. ТУЗ-ийн хараат бус гишүүдийг сонгох
Хүн тус бүрийн танилцуулга 15 мин
5. 2014 оны үр дүнгээр хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийг батлах тухай
ТУЗ-ийн н.б Л.Нямжав 10 мин
6. Хувьцаа эзэмшигчдийн хурлын болон ТУЗ-ийн 2015 оны үйл ажиллагааны зардлын төсвийг хэлэлцэж батлах тухай. ТУЗ-ийн н.б Л.Нямжав 10 мин
7. Компанийн дүрэмд оруулсан өөрчлөлтийг батлах тухай.
Хурлын дарга 15 мин
8. Санал, шүүмжлэл
(хүн тус бүрт 3 мин)
9. Хурлаас гарах шийдвэрт хувь нийлүүлэгчдийн өгсөн саналын дүнг танилцуулж батлуулах
1 (Тооллогын комиссын дарга) 15 мин
10. Хурлаас гарах шийдвэрийн төслийг батлах
(Хурлын дарга) цаг тогтоохгүй

Хурлыг 1.30 /нэг цаг гучин минутад/ цагт багтаан явуулна

Төлөөлөн Удирдах Зөвлөл

“Ариг гал” ХК-ийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны
2014 оны тайлан

Илтгэгч: ГЗ Х.Хания

Тус компанийн гүйцэтгэх удирдлага нь Компанийн дүрмээр олгогдсон эрх үүргийн хүрээнд, хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-өөс гаргасан хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх гарсан удирдамж шийдвэрийн дагуу компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажиллаа.

Тайлангийн жилд үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, охин компаниудыг менежментийн удирдлагаар хангах замаар үйлдвэрлэлт борлуулалтын тогтвортой өсөлтийг хангах, компанийн дотоод нөөц бололцоог дайчлан ашиглах замаар ашгийн нэмэгдүүлэхэд гол ажлаа чиглүүлж ажиллаа.

Компани нь 2014 онд цомхон аппараттайгаар үйл ажиллагааг хөтлөн явуулсан бөгөөд гүйцэтгэх удирдлага, гүйцэтгэх албан тушаалтан нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлалсан.

Нэг. Колмпанийн үйл ажиллагааны талаар

1. Тус компани 2014 онд барилга байгууламж, инженерийн байгууламжийн үйлчилгээгээр 118,993.14 мян.төг –ийн орлоготой ажилласан нь өмнөх оноос 29%-иар орлого өссөн байна

Энэ нь аж ахуйн нэгж байгууллагуудад түрээсийн болон өөрийн инженерийн байгууламжийн сүлжээгээр бохир ус зайлуулах, цэвэр ус зөөвөрлөх үйлчилгээ үзүүлэх, эрчим хүчний болон бусад зардлын өсөлтөд үндэслэсэн тооцоо судалгааны үндсэн дээр үнэ тарифыг шинэчлэх, олон жил ашиглагдахгүй байсан цэцэрлэгт хүрээлэнгийн талбайг түрээслэх үйл ажиллагааг өрөгжүүлсэнтэй холбоотой.

Өмнөх оны тайлангийн хурлаас хийхээр төлөвлөсөн 13 ажлаас 4 асуудал бүрэн шийдэгдсэн 5 асуудал хэрэгжилтийн шатандаа 4 ажил тасар сан байгаагаас дурдвал:

- Компанийн байрнаас нэмж түрээслэх бололцоотой хэсгийг түрээслэсэн
- Инженерийн шугам сүлжээгээр гадны байгууллагуудад үзүүлэх үйлчилгээний үнэлгээг нэмэгдүүлсэн
- Компанийн цэцэрлэгт хүрээлэнг хүүхдийн тоглоомын зориулалтаар түрээслэсэн
- Компанийн хашааны өмнөд хэсэгт автомашины зогсоолоор газрыг түрээслэн ашигласан ажлууд бүрэн биелэгдсэн.

Харин дараах төлөвлөсөн асуудлууд хэрэгжилтийн үе шатандаа явж байна.

- Компанийн агуулахад удаан ашиглалтгүй хадгалагдсан 105.0 сая.төг-ийн өртөг бүхий 886314ш сэлбэгийг худалдан борлуулах, охин компанийн үйл ажиллагаанд шилжүүлэн ашиглах зэргээр 4 ангилж ТУЗ-ийн шийдвэр гаргуулан зарим хэсгийг борлуулсан, цаашид борлуулах сувгыг тогтоож худалдах ажлыг зохион байгуулж эхлээд байна тайлангийн хугацаанд 68.0 сая.төг-ийн сэлбэгийг борлуулснаар нөөц 64.4%-иар буурсан. Харин дотоодын ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг Эрдэнэт хивс ХК Нэхээсгүй эдлэл ХК, Улаанбаатар хивс ХК-иудын тоног төхөөрөмж шинэчлэгдсэн тул дээрх сэлбэгийг борлуулах зах зээлгүй байдалд хүрсэн болно.
- Охин болон хөрөнгө оруулалттай компаниудаас ногдол ашиг төвлөрүүлэх талаар гэрээний төсөл боловсруулаад хэлэлцүүлж байна
- Авлага барагдуулах ажлыг эрчимжүүлж, авлагын 16.1% буюу 86.8 сая.төг-ийг шийдвэрлэж, үүссэн авлагын насжилтийг тогтоож, авлагын комисс гүйцэтгэлийн ажлыг зохион байгуулан сар бүр тайлагнан ажиллаж байна.
- Хэрэгцээнээс гарсан зарим отг ашиглагдахгүй хаягдал төмөр борлуулах ажил хэрэг жилтийн шатандаа байгаа

дараах асуудлууд хэрэгжээгүй Үүнд:

- Компанийн стадионыг бусдад ашигтайгаар түрээслэх
- Гүнийн худгын ус борлуулах асуудлыг төлөвлөсөн боловч хөрөнгө санхүүгийн хүндрэлтэй байдлаас ажил хойшлоод байна.
- Компанийн хашааны урдуур татсан дулааны шугамыг газар доогуур явуулах асуудлыг шийдвэрлүүлэх асуудлыг Улаанбаатар хотын захиргаанд тавьсан боловч өнөөг хүртэл шийдвэр гаргаж өгөөгүй байна.
- Цэцэрлэгт хүрээлэнд сэндвичэн объект барьж үйлчилгээний зориулалтаар ашиглан орлогынг эх үүсвэр гарах ажлууд шийдэгдээгүй.

Тайлант хугацаанд ТУЗ-ийн шийдвэр гаргуулан "Блю скай" ХХК-д 50.0 сая.төг-ийн хөрөнгө оруулалт хийж сандвичэн хавтангийн үйлдвэрийг оруулж ирэн суурилуулсан бөгөөд үйл ажиллагааг 2015 оноос эхлүүлэхээр төлөвлөөд ажиллаж байна.

Хоёр. Санхүүгийн үйл ажиллагааны талаар

1. "Ариг гал" ХК-ийн үндсэн үйл ажиллагааны орлого болох түрээсийн орлого 118.9 сая.төг болж өмнөх оноос 26.7 сая.төг буюу 29%-иар өслөө.

2. Тайлант онд хувьцаагаар хөрөнгө оруулалттай компаниас 1.5 тэрбум төрөг-ийн ноглол ашиг хуваарилуулж авсан нь өмнөх оноос 5 дахин өссөн. Үүний дийлэнх нь Таван толгой ХК-иас авсан ногдол ашиг эзэлж байна.

3. 2014 онд 1,937.0 сая.төг-ийн үйл ажиллагааны зардал гарснаас 52.9% буюу 1,024.6 сая.төг-ийг зээлийн хүүгийн зардал, 14.5% буюу 282.4 сая.төг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, 15.2% буюу 296.6 сая.төг цалин хөлс, нийгмийн даатгалын зардал, 6.2% буюу 119.8 сая.төг элэгдлийн зардал байна.

Тайлант онд 16.3 сая.төг-ийг ашгийн татвар, 33.7 сая.төг-ийг газрын төлбөр, 43.2 сая.төг-ийг үл хөдлөх хөрөнгийн татвар, 32.6 сая.төг-ийг нийгмийн даатгалаар нийт 115.8 сая.төг-ийг улсын төсөвт төлөрүүлсэн

4. Юны эцэст 42.5 тэрбум.төг-ийн авлагатай байна

5. Жилдээ 41.8 тэрбум төгрөгийн өглөгтэй байснаас 51.1 тэрбум төгрөг болж 9.3 тэрбум төгрөгөөр буюу 22.2 хувиар өссөн болно. Эдгээр өглөг нь үйл ажиллагаанд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрээр харилцагч компаниудаас авсан зээлийн өглөгүүд болно.

6. Эргэлтийн хөрөнгийн зээлд авсан өглөгөөс 15%-ийг графикийн дагуу төлсөн байна.

Гурав. Дүгнэлт, цаашид хийх ажлын талаар

Үйл ажиллагааныхаа хүрээнд компанийн дүрмийн дагуу охин ХХК-ийн өмнө болон гэрээ, хэлцлээр түншийн холбоотой компаниудын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, тэдгээрийн тогтвортой хэвийн ажиллагаанд тус дэм үзүүлэн санхүүжилтийн олон боломжтой хэлбэрийг ашиглан шийдвэрлэж байсны дээр илүүдэл сэлбэг, материалын борлуулалтыг зохих хэмжээнд шийдвэрлэж, өр авлагыг бууруулах талаар бололцоотой арга хэмжээ авч ажилласнаар тайлангийн жилд өмнөх оноос илүү үр дүнтэй ажиллаж, ашиг орлогоо нэмэгдүүлэх талаар багагүй ажил хийсэн.

Тайлант жилд бүтцийн өөрчлөлт хийснээс хойшх 5 дахь жил тохиож байгаа бөгөөд охин компаниудын үйл ажиллагаа жигдэрч байна. Гэвч эдийн засгийн хямдрал валютын өсөлтөөс өглөгийн хэмжээ нэмэгдсэн дүн харагдаж байна.

Улс орны нийгэм эдийн засгийн хямралтай байдлаас компанид байгаа их хэмжээний газар, барилга болон бусад хөрөнгө эргэлтэд орж чадахгүй түгжигдмэл байдалд орж байгаагаас компанийн эдийн засгийн нөхцөл байдал сайнгүй харагдаж байгаа.

Өөрөөр хэлбэл хөрөнгийг тодорхой үнэд хүрэх үед ашигтайгаар эргэлтэд оруулах боломжтой хөрөнгө нь байгаа учир өглөг нь хөрөнгөөр баталгаажсан болно.

Компанийн 2015 оны үйл ажиллагааг дараах үндсэн чиглэлээр төлөвлөж байна.

1. Компанийн тайлбайнаас бололцоотой хэсгийг суллаж бусдад түрээслэх
2. Цэцэрлэгт хүрээлэнд объект барьж үйлчилгээний зориулалтаар ашиглан түрээсийн орлогыг нэмэгдүүлэх
3. Авлага барагдуулах ажлыг эрчижүүлж, авлагыг 20-иос доошгүй хувиар бууруулах
4. Агуулахад байгаа сэлбэг бараа материалыг эргэлтэд оруулах борлуулах ажлыг зохион байгуулж нөөцийг 30-аас доошгүй хувиар бууруулах
5. Бизнесийн хүрээг өргөтгөх, барилгын үйлдвэрлэл, шинэ бизнес эрхлэх замаар ашгаа өсгөх
6. Стадионы талбайг үр ашигтай ашиглах төсөл боловсруулж хэрэгжүүлэх

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэр, санал дүгнэлтийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж компанийн ашгийг нэмэгдүүлэх бүхий л бололцоог ашиглаж ажиллах болно.

**“АРИГ ГАЛ” ХК-ИЙН 2014 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ХЯНАЛТЫН ТОГТОЛЦООНД ТУЗ-ӨӨС ӨГСӨН ДҮГНЭЛТ**

**Нэг. Санхүүгийн тайлан тэнцэл, хөрөнгө өр төлбөрийн өнөөгийн байдлаар
талаар**

Компанийн нийт хөрөнгө 70,0 тэрбум төгрөгт хүрч, тайлант жилийн хугацаанд 9.2 тэрбум төгрөгөөр буюу өнгөрсөн оны эцэстэй харьцуулахад 15,1 хувиар өссөн байна. Энэ өсөлтийн 72,8 хувь нь буюу 6,7 тэрбум төгрөг нь өмнөх жилүүдийн нэгэн адил авлагын өсөлт байна. Хөрөнгийн эх үүсвэрийн хувьд богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 9,4 тэрбум төгрөгөөр өсч, богино хугацаат зээлийн үлдэгдэл 14,2 сая төгрөгөөр буурсан байна. Группийн толгой компанийн үүрэг гүйцэтгэн охин компаниудын үйл ажиллагааг зохицуулах, санхүүжилтийн эх үүсвэрээр хангах үйл ажиллагаа эрхэлж байгаа учраас группийн доторх хоорондын тооцооны өглөг авлага, дийлэнх хувийг эзэлж байгаа боловч, авлагыг насжилтаар нь ангилан найдваргүй болсон хэсгийг данснаас хасах, өр төлбөрийн зарим хэсгийг холбогдох компанийн данс бүртгэлд шилжүүлэн бүртгэх зэргээр зохицуулалт хийх шаардлагатай байдал харагдаж байна. Гэхдээ авлагын үлдэгдэл, өрийн үлдэгдэл зөрүүтэй байгаа, цаашдаа санхүүгийн байдлын үзүүлэлт буурах хандлагатай байгаа учраас цаашид хэрхэх талаар ТУЗ 2-р улиралд хэлэлцэх нь зүйтэй. Өнгөрсөн жилийн тайланд анхааруулсан боловч нийт хөрөнгийн 34,1 хувийг эзэлж буй бусад эргэлтийн бус хөрөнгийн талаарх тайлбараа санхүүгийн тайлангийн тодруулгад тусгаагүй хэвээр байна. Энэ хөрөнгийн 77 орчим хувь нь охин компанид оруулсан хөрөнгө оруулалт, үлдэх хэсэг нь хуримтлуулан тооцсон хүүгийн зардал байгаа юм байна. Энэ зардлыг цаашид хэрхэн бүртгэлд тусгаж барагдуулах асуудлыг анхаарах нь зүйтэй байна.

Хоёр. Орлого

Ариг гал ХК нь үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагааг охин компаниудад шилжүүлж, үйл ажиллагааг нь зохицуулах, санхүүжилтийн эх үүсвэрийг хангах зэргээр холдингийн толгой компанийн үүргийг гүйцэтгэн ажиллаж байгаа учраас нь орлогын эх үүсвэр нь:

А. Ногдол ашиг	1458,1 сая төгрөг
Б. Түрээсийн орлого	119,0 сая төгрөг
В. Хүүгийн орлого гэсэн хэлбэртэй байна.	170,0 сая төгрөг байна.

Түрээсийн орлого 119,0 сая төгрөг болж өнгөрсөн оныхоос 26,5 сая төгрөгөөр, ногдол ашгийн орлого өнгөрсөн оныхоос 1158,1 сая төгрөгөөр тус тус өсч, хүүгийн орлого 748,8 сая төгрөгөөр буурсан байна. Эндээс үзэхэд охин компанид олгосон зээлийн хэмжээ өссөн хэдий ч зээлийн хүүгээ бууруулах замаар тэдгээрийн үйл ажиллагааны зардлыг бууруулж, санхүүгийн хувьд дэмжих бодлого баримталсан нь үр дүнд хүргэсэн байна гэж дүгнэж байна.

Түрээсийн орлогын хувьд 26,5 сая төгрөгийн өсөлт байгаа нь инженерийн байгууламжийн шугам сүлжээний үйлчилгээ үзүүлэх үнэ тарифыг эрчим хүч болон бусад зардлын өсөлтийг харгалзан түрээсийн үнэ тарифыг шинэчлэн тогтоосон, цэцэрлэгт хүрээлэнгийн талбайг түрээслэх болсонтой холбоотой байна.

Мөн компанид олон жил хадгалагдсан цаашид ашиглах боломжгүй сэлбэг хэрэгсэлийг балансын үнээр нь охин компанид борлуулж, энэ асуудал үндсэндээ шийдвэрлэгдсэн гэж үзэж болохоор байна. Одоо үлдсэн хэсгийг хаягдал төмөрт шилжүүлэн борлуулах шаардлагатай байна.

3. Зардал

Тайлант онд нийт зардал өнгөрсөн оныхоос зардлын хэмжээ өссөн үүнээс 98.8% нь зээлийн хүүгийн зардал эзэлж байна. Өөрөө аж хуйн ямар нэг үйл ажиллагаа эрхлээгүй эзэл авах, охин компанид зээлийн болон бусад хэлбэрээр санхүүжилт хийх ажиллагаа эрхэлж байгаагийн хувьд хүүгийн орлогоос, зардал өндөр байгаа нь хэвийн бус үзэгдэл гэдгийг анхаарлдаа авч, шалтгаан, цаашид авах арга хэмжээг ТУЗ-д танилцуулах шаардлагатай байна. Бусад зардлын хувьд хэвийн хэмжээнд байна.

4. Санхүү эдийн засгийн ерөнхий төлөв

Санхүү эдийн засгийн ерөнхий үзүүлэлтүүд өнгөрсөн оны түвшинд байна. Энэ нь гадаад валютын ханшийн зөрүүнээс багагүй хэмжээний ашиг олсонтой холбоотой байна. Өөрөөр хэлбэл толгой компанийн хувьд хэрэгжүүлсэн санхүүгийн үйл ажиллагаа нь оновчтой байж чадаагүй боловч цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой олсон төлөвлөгөөт бус ашиг байдлыг зөөлрүүлэх нөлөө үзүүлжээ. Цаашид толгой компанийн хувьд хэрэгжүүлж буй арга хэмжээг хэвийн түвшинд хүргэх талаар нухацтай хэлэлцэж арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай болоод байна. Удирдлагын тайланд өглөг авлагын тооцоо түүний өөрчлөлт, ашгийн түвшин, ногдол ашиг олох боломж зэргийг охин компани тус бүрээр харуулж, дүгнэлттэй тайлагнадаг байхыг анхааруулж байна.

Мөн түүнчлэн өнгөрсөн оны дүгнэлтэд толгой компанийн хэлбэртэй ажиллах болсны улмаас бүтэц зохион байгуулалтад орсон өөрчлөлт үүнтэй холбоотой хэрэгжүүлж байгаа удирдлага, хяналтын арга хэмжээ, дүрэм журам тогтоосон байдал зэргийг тайлагнаж байхыг анхааруулсан боловч энэ жил мөн л энэ асуудлыг тусгаагүй хэвээр байна.

Аудитын компанийг сольж, энэ жилийн хувьд аудиторын дүгнэлт гаргах ажилд ахиц гарсан байна.

Дүгнэлт

Өнгөрсөн жилийн тайлангаар өгсөн зарим үүрэг биелэгдээгүй байгааг болон охин компани тус бүрээр гүйцэтгэлийг тайландаа тусгадаг байхыг дахин анхааруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Мөн түүнчлэн Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлд заасан асуудлыг бүрэн тусгасан тайланг толилуулж байх нь зүйтэй.

ТУЗ-ийн АУДИТЫН ХОРОО

Хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангаж ажиллах журмын хэрэгжилтийн талаар

1. Компани нь хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангах зорилгоор 2014 оны 1-р улирлаас Ариг гал ХК гэсэн веб сайт нээж ажиллуулж байна. Уг веб сайтад ХЭХ-ийн шийдвэр, ТУЗ-ийн гишүүдийн танилцуулга, компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн товч балансыг байрлуулан хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангаж байна.

Мөн 2015 оны ээлжит хурлын зар, Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдийн танилцуулга, 2014 оны жилийн эцсийн баланс байршуулсан байгаа

“АРИГ ГАЛ” ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 04 дугаар сарын
29-ны өдөр

Дугаар 01/15

Улаанбаатар хот

Компанийн хувьцаа эзэмшигчдийн
хурлын саналын дүнгийн тухай

“Ариг гал” ХК - ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудсыг тоолсон тухай тооллогын комиссын 2015 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 01/15 тоот тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын ердийн олонхийн хувийн саналаар компанийн 2014 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны талаарх гүйцэтгэх захирлын тайлан, Компанийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд өгсөн ТУЗ-ийн дүгнэлт, аудитын байгууллагаас Компанийн санхүүгийн тайлан, нягтлан бодох үйл бүртгэлийн ажиллагаанд өгсөн дүгнэлтийг тус тус зөвшөөрсүгэй.

2. Хуралд оролцогчдын кумулятив санал буюу%-ийн саналаар С.Мөнхжаргалыг, кумулятив санал буюу%-ийн саналаар Д.Гиваапилыг, кумулятив санал буюу%-ийн саналаар Б.Ёндонжамцыг, кумулятив санал буюу%-ийн саналаар Д.Мөнхбатыг, кумулятив санал буюу%-ийн саналаар Х.Ханияг, кумулятив санал буюу%-ийн саналаар С.Баяр нарыг “Ариг гал” ХК-ийн ТУЗ-ийн энгийн гишүүнээр сонгосугай.

3. Хуралд оролцогчдын кумулятив санал буюу %-ийн саналаар Б.Аюушийг, кумулятив санал буюу %-ийн саналаар Э.Бямбажавыг, кумулятив санал буюу %-ийн саналаар Б.Болдыг “Ариг гал” ХК-ийн хараат бус гишүүнээр сонгосугай.

4. Хуралд оролцогчдын ердийн санал буюу%-ийн саналаар компанийн 2014 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийг нэгж хувьцаанд 42.51 төгрөг /дөчин хоёр төгрөг 51 мөнгө/ буюу нийт 144,080,500.00₮ /нэг зуун дөчин дөрвөн сая наян мянга таван зуун төгрөг 00 мөнгө/- өөр тогтоосугай.

5. Хуралд оролцогчдын ердийн санал буюу%-ийн саналаар компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын болон ТУЗ-ийн 2015 оны зардлын төсвийг 52764.0 мян.төг /тавин хоёр сая хоёр долоон зуун жаран дөрвөн мянган/- өөр зөвшөөрсүгэй.

6. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдийн санал буюу%-ийн саналаар “Ариг гал” ХК-ийн дүрэмд хаягын шинэчлэлтийг тусгаж өөрчлөлт оруулсугай.

7. Хувьцаа эзэмшигчдийн саналын дүнг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж батлуулахыг тооллогын комиссын дарга /Х.Оюунгэрэл/-д үүрэг болгосугай.

“Ариг гал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын
тооллогын комиссын

Дарга:..... /Х.Оюунгэрэл/

Гишүүдэд:...../С.Дэнсмаа/

...../Б.Цолмон/

“АРИГ ГАЛ” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТООЛЛОГЫН КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2015 оны 04 дугаар сарын
29-ны өдөр

Дугаар 01/15

Улаанбаатар хот

“Ариг гал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комисс нь Х.Оюунгэрэл, С.Дэнсмаа, Б.Цолмон нарын бүрэлдэхүүнтэй ажиллаа.

Саналын хайрцагыг задлахад нийт санал бүхий ширхэг саналын хуудас гарснаас хүчнгүй хуудас байхгүй саналын эрх бүхий саналын хуудас тоологдлоо.

1. Хүчинтэй саналын хуудаснаас санал буюу хуралд оролцогчдын хувийн саналаар, компанийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны талаар гүйцэтгэх удирдлагаас тавьсан тайланг батлах хувийн саналаар ТУЗ-өөс компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа санхүүгийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг батлах, компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудитын байгуулаагаас хийсэн дүгнэлтийг зөвшөөрсөн санал өгсөн байна.
2. ТУЗ-ийн энгийн гишүүдээр Хуралд оролцогчдын кумулятив санал буюу%-ийн саналаар С.Мөнхжаргалыг, кумулятив санал буюу%-ийн саналаар Д.Гиваапилыг, кумулятив санал буюу%-ийн саналаар Б.Ёндонжамцыг, кумулятив санал буюу%-ийн саналаар Д.Мөнхбатыг, кумулятив санал буюу%-ийн саналаар Х.Ханияг, кумулятив санал буюу%-ийн саналаар С.Баярыг, кумулятив санал буюу%-ийн саналаар Л.Бүрэнгшийг, кумулятив санал буюу%-ийн саналаар Х.Эрдэнэбаяр нарыг сонгосон санал өгсөн байна.нарын санал ТУЗ-д сонгогдох саналд хүрээгүй
3. ТУЗ-ийн хараат бус гишүүдээр хуралд оролцогчдын кумулятив санал буюу%-ийн саналаар Б.Аюушийг, кумулятив санал буюу%-ийн саналаар Э.Бямбажавыг, кумулятив санал буюу%-ийн саналаар Б.Болдыг сонгосон санал өгчээ.
4. Хуралд оролцогчдийн санал буюу хувийн саналаар 2014 оны ногдол ашгыг нэгж хувьцаанд 42.51 төгрөгөөр нийт 144,080,500.00₮ /нэг зуун дөчин дөрвөн сая наян мянга таван зуун төгрөг 00 мөнгө/- өөр батлах санал өгсөн.
5. Хуралд оролцогчдийн санал буюу хувийн саналаар ТУЗ-ийн 2015 оны зардлын төсвийг 52764.0 мян.төг /тавин хоёр сая хоёр долоон зуун жаран дөрвөн мянган/-өөр баталах санал өгсөн байна.
6. Хувьцаа эзэмшигчдийн хурлын болон ТУЗ-ийн үйл ажиллагааны 2015 оны зардлын төсөвийг Хуралд оролцогчдийн санал буюу хувийн саналаар 52764.0 мян.төг /тавин хоёр сая хоёр долоон зуун жаран дөрвөн мянган/-өөр батлах санал өгсөн байна.
7. Хуралд оролцогчдийн санал буюу хувийн саналаар Ариг гал ХК-ийн дүрэмд оруулсан өөрчлөлтийг батлах санал өгчээ.
8. Тоологын комиссын тооллогын дүнгээр тооллогын комиссын тогтоолыг төлөвлөж хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж батлуулахыг тооллогын комиссын дарга /Х.Оюунгэрэл/-д үүрэг болгов.

“Ариг гал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын

тооллогын комиссын

Дарга:...../Х.Оюунгэрэл/

Гишүүдэд:...../С.Дэнсмаа/

...../Б.Цолмон/